



**Байнгын бус ажиллагаатай  
сонгуулийн байгууллагын ажлын  
зохион байгуулалт**

**[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)**



# Эрх зүйн үндэс

---

- Сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм  
*УИХ-ын 2008 оны 25 дугаар тогтоол*
- Сонгуулийн хорооны хуралдааны дэг  
*Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 10 дугаар тогтоол*
- Эрх зүйн бусад баримт бичиг.



# Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага

Аймаг,  
нийслэл

22 хороо

Сум, дүүрэг

340 хороо

Санал авах  
байр

2078 хэсэг  
2016.9.20

✎ Ажилтан нь сонгуулийн хууль тогтоомжийн талаарх сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байна.



# Ажлын зохион байгуулалт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн  
сонгуулийн хорооны үйл ажиллагааны  
хэлбэр нь **ХУРАЛДААН** байна.



# Хуралдааны бэлтгэл хангах:

**Хэлэлцэх асуудал, хуваарийг гаргаж  
мэдээллийн самбарт ил тавина.**

**Нарийн бичгийн дарга нь:**

- баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг бүрдүүлэх, бэлтгэх, олшруулах, бүртгэх, тэмдэг дарах, тараах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.
- хэлэлцэх асуудлын төсөл, танилцуулга, баримт бичгийг хуралдаанаас өмнө Хорооны гишүүдэд хүргүүлсэн байна.



## Хуралдааны бэлтгэл хангах:

### Хорооны гишүүд нь:

- Хуралдаанд оролцох боломжгүй бол шалтгаанаа Хорооны даргад бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- Сонгуулийн хорооны ажилтан, албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдааныг орхисон, тасалсан тохиолдолд хуралдааны ирцэд тооцон, **ТАТГАЛЗСАН САНАЛ ГАРГАСАНД ТООЦНО.**



# Хуралдаан

---

- Дарга удирдан явуулна.
- Түүний эзгүйд Хорооны даргын даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргална.

## Хуралдаанд:

- улс төрийн нам,
- сонгуулийн штабын ажилтан,
- хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан,
- ажиглагч,
- ТББ-ын бус байгууллагын ажилтныг байлцуулж болно.

➤ *Байрны багтаамжыг харгалзана.*

➤ *Хуралдаанд оролцогчид хуралдааны дэгийг чанд сахих үүрэгтэй.*



# Хуралдааны явцад баримтлах журам

## Дарга нь:

- Хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулах, батлуулах;
- Төлөвлөгөөнд ороогүй боловч яаралтай, зайлшгүй хэлэлцэх асуудлыг санал оруулан хуралдаанд оролцсон гишүүдийн **ОЛОНХИЙН саналаар шийдвэрлүүлнэ.**
  - нэн яаралтай,
  - зайлшгүй шаардлагатай хэлэлцэх асуудал гарвал
- Хуралдаан даргалагч гарсан саналыг нэгтгэж, санал тус бүрийг шийдвэрлүүлэх.





# Хуралдааны явцад баримтлах журам

## Гишүүд:

- Илтгэл, сонсголыг сонссоны дараа асуулт тавина.
- Асуулт, хариулт дууссаны дараа үг хэлэх хүсэлт гаргасан дарааллаар саналаа гаргана.
- Асуулт, хариулт, санал нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай
  - шууд холбоотой
  - товч тодорхой
  - давтагдахгүй байна.



# Хуралдааны явцад баримтлах журам

## Гишүүд:

- түр гарах бол хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.
- Хэлэлцэж буй асуудлаар зөвшөөрсөн эсвэл татгалзсан тухай саналын аль нэгийг заавал өгөх үүрэгтэй.



# Хуралдааны ТЭМДЭГЛЭЛ

- Хорооны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлнө.
- Нарийн бичгийн дарга хуралдаанд оролцоогүй үед хуралдаан даргалагчийн даалгаснаар аль нэг ажилтан хөтөлнө.



# Хуралдааныг баримтжуулах, шийдвэрийг ёсчлон гаргах

- Шийдвэрийг нэн даруй ёсчлон гаргана.
- Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, гарын үсэг зурсан шийдвэрийн эх хувийг архивт шилжүүлнэ.
- Шийдвэрлэсэн асуудалд зарчмын өөрчлөлт оруулах бол **ЗААВАЛ** хуралдаанаар дахин хэлэлцэж шийдвэрлэнэ.



# Ажлын цаг

---

- Санал авах өдрөөс бусад ажлын өдөр ажлын цагийн хуваариар ажиллана.
- Шаардлагатай бол ажлын бус өдөр, илүү цагаар ажиллаж болно. (*нам, эвсэл, нэр дэвшигчийн бичиг баримт хүлээн авах үе гэх мэт*)
- Хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлнэ.

Цагийн хуваарь, ажил үүргийн хуваарийг  
**МЭДЭЭЛЛИЙН САМБАРТ** заавал байрлуулна.



# Үйл ажиллагааны баталгаа

- Үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, өөрийнх нь зөвшөөрөлгүй өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно..
- Төрийн байгууллага цалинтай чөлөө олгоно.
- Эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно.



# Ёс зүйн дүрэм

---

“Сонгуулийн хорооны гишүүний  
ёс зүйн дүрэм”

УИХ-ын 2008 оны 25 дугаар тогтоол



# Ёс зүйн дүрэм нь:

- сонгуулийг шударга, зөв зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх
- сонгуулийн хорооны гишүүн сонгуулийн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх,
- Сонгуулийн хорооны гишүүдийг аливаа зөрчил, хууль бус үйлдлээс сэргийлж, нэр төрийг нь хамгаалахад чиглэгдэнэ.





# Ёс зүйн хэм хэмжээ

## Хорооны гишүүн нь:

- Сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн хорооноос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөнө.
- Хорооны үйл ажиллагаа нь ил тод явагдана.
  - мэдээллийг нуун дарагдуулах,
  - цаг алдуулахыг **ЦЭЭРЛЭНЭ**.



# Ёс зүйн хэм хэмжээ

## Хорооны гишүүн нь:

- Сонгогчийн эрхийг хүндэтгэн соёлтой харилцаж, сонгуулийн хууль тогтоомж, үйл ажиллагааг үнэн зөв ойлгуулах;
- Нам, эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагааг
  - Дэмжих
  - Шүүмжлэх
  - Эсэргүүцэх бус**улс төрийн хувьд төвийг сахин ажиллана.**



# Ёс зүйн хэм хэмжээ

## Олонхийн шийдвэрийг:

- Хүндэтгэн мөрдөж ажиллах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ташаа буюу гуйвуулсан тайлбар хийхийг цээрлэнэ.



# Хориглоно:

---

- шийдвэр гаргахад бусад гишүүдэд нөлөөлөх;
- хуралдаан таслах, хаяж явах;
- сонгуулийн ажил гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;
- баримт бичиг хуурамчаар үйлдэх,
- сонгуулийн дүнг зориудаар буруу ташаа гаргах,
- сонгогч саналаа нууцаар чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчих
- сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлөх.



# Хариуцлага

---

- Сануулах
  - эхний удаад сануулна.
- Хорооны бүрэлдэхүүнээс огцруулах
- Захиргааны хариуцлага
  - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан торгох
- Сахилгын шийтгэл
  - 1-2 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах



[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)